СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2026 V

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| | ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр | 4 |
| I | ЭРҮҮЛ МЭНД | 5 |
| II | ТӨСӨВ | 10 |
| III | НИЙГМИЙН ДААТГАЛ | 15 |
| IV | НИЙГМИЙН ХАЛАМЖ | 18 |
| V | ГЭМТ ХЭРЭГ | 21 |
| VI | ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 28 |
| | ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ | 33 |

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI … г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
* урьдчилсан гүйцэтгэл
** дахин их
¹ товчилсон үгийн тайлбар

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2022 I-V | 2023 I-V | 2024 I-V | 2025 I-V | 2026 I-V |
|---|---|---|---|---|---|---|---|
| Шинээр төрсөн хүүхэд | | Хүн | 13 286 ↓13.1 | 14 639 ↑10.2 | 13 110 ↓10.4 | 12 213 ↓6.8 | 12 178 ↓0.3 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | | Хүн | 149 060 ↑7.1** | 10 050 ↓93.3 | 7 941 ↓21.0 | 14 392 ↑81.2 | 11 764 ↓18.3 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | | Тоо | 11 573 ↑1.9* | 12 004 ↓3.7 | 12 206 ↑1.7 | 16 331 ↑33.8 | 16 985 ↑4.0 |
| Хэрэглээний үнийн индекс, (жилийн өөрчлөлт) | | Хувь | 2.9 ↑0.5 | 1.1 ↓1.8 | 0.7 ↓0.4 | 0.1 ↓0.6 | 0.9 ↑0.8 |
| Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж) | Доллар (АНУ) | Төгрөг | 3 110 ↑9.1 | 3 461 ↑11.3 | 3 381 ↓2.3 | 3 573 ↑5.7 | 3 576 ↑0.1 |
| | Юань (БНХАУ) | Төгрөг | 464 ↑4.7 | 495 ↑6.7 | 467 ↓5.7 | 495 ↑6.0 | 525 ↑6.1 |
| | Рубль (ОХУ) | Төгрөг | 48 ↑23.1 | 44 ↓8.3 | 37 ↓15.9 | 44 ↑18.9 | 49 ↑11.4 |
| Нийслэлийн төсвийн орлого | | Тэрбум төгрөг | 528.9 ↑26.9 | 740.3 ↑40.0 | 1 167.3 ↑57.7 | 1 484.7 ↑27.2 | 1 589.1 ↑7.0 |
| Нийслэлийн төсвийн зарлага | | Тэрбум төгрөг | 464.2 ↑9.2 | 698.0 ↑50.4 | 1 123.5 ↑61.0 | 1 711.1 ↑52.3 | 2 050.2 ↑19.8 |
| Агаарын дундаж температур | | $^0C$ | 3.4 | 8.8 | 13.2 | 10.9 | 11.6 |

** Дахин их

## ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2025 I-V | | | | | 2026 I-V | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | |
| Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/ | Тоо | 357 | Баянгол | 8 797 | Налайх | 59 | 357 | Баянгол | 8 797 | Налайх | 59 |
| | | | Чингэлтэй | 1 490 | Багануур | 47 | | Чингэлтэй | 1 490 | Багануур | 47 |
| | | | Сүхбаатар | 688 | Багахангай | 32 | | Сүхбаатар | 688 | Багахангай | 32 |
| Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/ | 0\00* | 15 | Багануур | 22 | Хан-Уул | 9 | 14 | Налайх | 30 | Хан-Уул | 9 |
| | | | Сүхбаатар | 16 | Баянгол | 9 | | Багахангай | 18 | Баянгол | 6 |
| | | | Налайх | 15 | Багахангай | - | | Баянзүрх | 13 | Багануур | - |
| 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд | 0\000 | 87 | Баянзүрх | 85 | Сонгино-хайрхан | 60 | 70 | Багануур | 108 | Баянгол | 48 |
| | | | Багануур | 81 | Налайх | 27 | | Баянзүрх | 70 | Налайх | 34 |
| | | | Чингэлтэй | 71 | Багахангай | 27 | | Чингэлтэй | 57 | Багахангай | 7 |
| Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100 | тоо | 87 | Сүхбаатар | 118 | Багахангай | 91 | 78 | Баянзүрх | 128 | Багахангай | 81 |
| | | | Хан-Уул | 115 | Багануур | 78 | | Хан-Уул | 124 | Багануур | 60 |
| | | | Баянзүрх | 113 | Налайх | 26 | | Чингэлтэй | 108 | Налайх | 24 |
| 16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг | тоо | 148 | Сүхбаатар | 247 | Сонгино-хайрхан | 78 | 153 | Сүхбаатар | 256 | Налайх | 89 |
| | | | Чингэлтэй | 179 | Налайх | 42 | | Чингэлтэй | 206 | Багахангай | 63 |
| | | | Баянгол | 168 | Багахангай | 29 | | Баянгол | 179 | Багануур | 55 |

# ЭРҮҮЛ МЭНД
## 2026 оны эхний V сард

| | 2025 V | 2026 V | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Амаржсан эх | 2159 | 2087 | 3.3% ↓ |
| Шинээр төрсөн хүүхэд | 2169 | 2116 | 2.4% ↓ |
| Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд | 2051 | 1634 | 20.2% ↓ |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 26 | 26 | |
| 1-5 насны хүүхдийн эндэгдэл | 4 | 4 | |

# ЭРҮҮЛ МЭНД

## Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний V сард 1637 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 414 (20.2%) хүнээр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны 5 дугаар сарын байдлаар 1637хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 414 (20.2%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 11.9 (94.1%) хүнээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 73 (4.5%) цусан суулга, 53 (3.2%) улаан эсэргэнэ, 12 (0.7%) гепатит, 217 (13.3%) салхин цэцэг, 4 (0.2%) гахайн хавдар, 17 (1.0%) сальмонеллёз, 6 (0.4%) ёлом, 467 (28.5%) гар хөл, амны өвчин, 142 (8.7%) улаанбурхан, 13 (0.8%) хоолны хордлого, 33 (2.5%) эритема B08.3, 143 (8.7%) тэмбүү, 66 (4.5%) заг хүйтэн, 129 (7.9%) шинээр илэрсэн сүрьеэ, 83 (5.2%) трихомониаз, 60 (3.7%) B34.1 энтеровируст халдвар, 101 (6.2%) бусад халдварт өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнийг өмнөх онтой харьцуулахад гепатит 1 (7.7%), салхинцэцэг 116 (34.8%), гахайн хавдар 2 (33.3%), сальмонеллёз 4 (19%), ёлом 9 (60%), улаан бурхан 515 (78.4%), хоолны хордлого 33 (71.7%), эритема B08.3 43 (56.6%), тэмбүү 46 (24.3%), заг хүйтэн 42 (38.9%), трихомониаз 19 (16%), B34.1 Энтеровируст халдвар 17 (22.1%) тус тус буурсан байна. Харин цусан суулга 18 (32.7%), улаан эсэргэнэ 19 (55.9%), ГХА өвчин 391 (6.1 дахин), шинэ илэрсэн сүрьеэ 6 (4.9%) тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 3.** **ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний V сард**

| Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | 2024 I-V | 2025 I-V | 2026 I-V | Өсөлт, бууралт 2026/2025 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо/нэгж | хувь |
| НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН | Бодит тоо | 1048 | 2051 | 1637 | -414 | -20.2 |
| Үүнээс цочмог халдварт өвчин | Бодит тоо | 630 | 1435 | 1108 | -327 | -22.8 |
| Цусан суулга | Бодит тоо | 115 | 55 | 73 | 18 | 32.7 |
| Улаан эсэргэнэ | Бодит тоо | 44 | 34 | 53 | 19 | 55.9 |
| Менингит | Бодит тоо | 0 | 0 | 1 | 1 | - |
| Гепатит | Бодит тоо | 10 | 13 | 12 | -1 | -7.7 |
| Салхинцэцэг | Бодит тоо | 282 | 333 | 217 | -116 | -34.8 |
| Гахайн хавдар | Бодит тоо | 19 | 6 | 4 | -2 | -33.3 |
| Сальмонеллёз | Бодит тоо | 20 | 21 | 17 | -4 | -19.0 |

| Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | 2024 I-V | 2025 I-V | 2026 I-V | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2026/2025 | |
| | | | | | тоо/нэгж | хувь |
| Ёлом | Бодит тоо | 9 | 15 | 6 | -9 | -60.0 |
| ГХА өвчин | Бодит тоо | 118 | 76 | 467 | 391 | 6.1** |
| Улаан бурхан | Бодит тоо | 0 | 657 | 142 | -515 | -78.4 |
| Хоолны хордлого | Бодит тоо | 12 | 46 | 13 | -33 | -71.7 |
| Эритема В08.3 | Бодит тоо | 0 | 76 | 33 | -43 | -56.6 |
| Тэмбүү | Бодит тоо | 175 | 189 | 143 | -46 | -24.3 |
| Заг хүйтэн | Бодит тоо | 20 | 108 | 66 | -42 | -38.9 |
| Шинэ илэрсэн сүрьеэ | Бодит тоо | 123 | 123 | 129 | 6 | 4.9 |
| Трихомониаз | Бодит тоо | 100 | 119 | 100 | -19 | -16.0 |
| В34.1 Энтеровирүст халдвар | Бодит тоо | 0 | 77 | 60 | -17 | -22.1 |
| Бусад халдварт өвчин | Бодит тоо | 1 | 103 | 101 | -2 | -1.9 |

**дахин их

**ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ТӨРЛӨӨР**




2026 оны 5 дугээр сарын байдлаар 2087 эхээс 2116 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 2159 эхээс 2169 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 26 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 4 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил байна.

## ХҮСНЭГТ 4. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний V сард

| Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | Эхний улирал | | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 I-V | 2025 I-V | 2026 I-V | Тоо | Хувь |
| Амаржсан эхийн тоо | тоо | 2392 | 2159 | 2087 | -72 | -3.3 |
| Амьд төрсөн хүүхэд | тоо | 2400 | 2169 | 2116 | -53 | -2.4 |
| Нийт нас баралт | тоо | 737 | 699 | 680 | -19 | -2.7 |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | тоо | 29 | 26 | 26 | 0 | 0.0 |
| 1-5 насны хүүхдийн эндэгдэл | тоо | 6 | 4 | 4 | 0 | 0.0 |
| Төрөхийн улмаас эндсэн эх | тоо | 2 | 0 | 1 | 1 | |

Эмнэлгийн байгууллагууд 2026 оны 5 дугаар сарын байдлаар 544483 хүн үзлэг хийсний 212176 (38.9%) нь урьдчилан сэргийлэх, 134843 (24.8%) нь гэрийн үзлэг байна.

Тайлант хугацаанд 167 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 8 (4,8%) нь цус багадалттай, 3 (1.8%) тэмбүү өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 162 (97.0%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна. 2026 оны 5 дугээр сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 66054 хүн хамрагдсанаас 39693 (60.1%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 1478 (2.2%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 41925 хүн хамрагдсанаас 24589 (58.6%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан нийт хүний 14594 (56.9%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 9488 (37.0%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 1538 (6.1%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

Тайлант хугацаанд 0-5 насны 15568 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгахад 0-5 насны хүүхдүүдийн 19 (0.1%) нь туранхай, 18 (0.1%) нь тураалтай, 10 (0.06%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 10329 хүүхэд А амин дэм, 6540 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

## Ойлголт, тодорхойлолт:

**Амьд төрөлт:**
Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл

эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):

Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв

## ДҮҮРГИЙН ТӨСӨВ
**2026 оны V сар, тэрбум төгрөг**




Төсвийн орлогын бүтэц




Татварын орлогын бүтэц



# ДҮҮРГИЙН ТӨСӨВ

**Төсвийн орлогын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өссөн байна.**

Дүүргийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны V сард 69216.7 (77.1%) сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 20581.8 (22.9%) сая төгрөгөөр дутуу бүрдсэн бол өмнөх оны мөн үеэс 4116.3 (6.3%) сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн нийт орлогын гүйцэтгэлийн 65859.7 (95.2%) сая төгрөгийг татварын орлого, 3357.0 (5.1%) сая төгрөгийг татварын бус орлого бүрдүүлжээ. Нийт татварын орлогод 54258.0 (82.4%) сая төгрөгийг орлогын албан татвар, 2726.0 (4.1%) сая төгрөгийг өмчийн татвар, 6055.0 (9.2%) сая төгрөгийг газрын төлбөр, 2820.7 (4.3%) сая төгрөгийг бусад төлбөр хураамж тус тус эзэлж байна. Тайлант оны татварын орлогын дүн өмнөх оны V сараас 2549.2 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна.

**ХҮСНЭГТ 5. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ ЭХНИЙ V САРД**

| Үзүүлэлт | Төсвийн орлого/сая.төг/ | | | | Өөрчлөлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| | 2025 I-V | | 2026 I-V | | |
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 78 075.7 | 65 100.4 | 89 798.5 | 69 216.7 | -22.9 |
| 1. Татварын орлого | 74 293.4 | 63 310.5 | 87 132.4 | 65 859.7 | 4.0 |
| 1.1 Орлогын албан татвар | 60 803.1 | 51 904.6 | 72 806.3 | 54 258.0 | 4.5 |
| 1.1.1Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 34 206.6 | 32 562.6 | 44 292.5 | 37 831.8 | 16.2 |
| 1.1.2 Үйл ажиллагааны орлого | 3 750.0 | 3 362.5 | 4 745.2 | 3 902.8 | 16.1 |
| 1.1.3. Хөрөнгийн орлого | 5 375.0 | 4 043.4 | 6 126.7 | 3 203.9 | -20.8 |
| 1.1.4. Хөрөнгө борлуулсны орлого | 3 200.0 | 2 810.6 | 4 694.2 | 5 485.5 | 95.2 |
| 1.1.5. Хувь хүнээс суутгасан ОАТ | 14 271.5 | 9 125.5 | 12 947.7 | 3 834.0 | -58.0 |
| 1.2. Өмчийн татвар | 1 777.1 | 2 502.0 | 3 839.7 | 2 726.0 | 9.0 |
| 1.2.1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1 750.0 | 2 468.7 | 3 808.1 | 2 693.6 | 9.1 |
| 1.2.2. Бууны албан татвар | 22.0 | 23.8 | 21.6 | 20.9 | -12.2 |
| 1.2.3. Малын тоо толгойн албан татвар | 5.,1 | 9.5 | 10.0 | 11.5 | 21.1 |
| 1.3. Газрын төлбөр | 8 124.9 | 5 869.1 | 6 972.0 | 6 055.0 | 3.2 |
| 1.3.1. Газрын төлбөр | 8 124.9 | 5 869.1 | 6 972.0 | 6 055.0 | 3.2 |
| 1.4. Дотоодын бараа үйлчилгээний татвар | 23.2 | 11.6 | 25.6 | 0.3 | -97.4 |
| 1.4.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 23.2 | 11.6 | 25.6 | 0.3 | -97.4 |
| 1.5. Бусад нийтлэг төлбөр хураамж | 3 565.1 | 3 023.2 | 3 488.9 | 2 820.4 | -6.7 |
| 1.5.1. Улсын тэмдэгтийн хураамж | 1 074.3 | 170.3 | 185.4 | 182.9 | 7.4 |

| Үзүүлэлт | Төсвийн орлого/сая.төг/ | | | | Өөрчлөлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| | 2025 I-V | | 2026 I-V | | |
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 1.5.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 2 486.9 | 2 841.4 | 3 296.4 | 2 628.2 | -7.5 |
| 1.5.3 Ус рашаан ашигласны төлбөр | 3.9 | 11.5 | 7.1 | 9.3 | -19.1 |
| 2.Татварын бус орлого | 3 782.3 | 1 789.9 | 2 665.8 | 3 357.0 | 87.6 |
| 2.1. Хүү, торгуулийн орлого | 1 144.8 | 733.3 | 778.7 | 1 656.0 | 125.8 |
| 2.2. Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 98.0 | 77.9 | 207.1 | 78.9 | 1.3 |
| 2.3. Бусад орлого | 2 539.5 | 978.7 | 1 680.0 | 1 622.1 | 65.7 |

*Мэдээллийн эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс*

## ЗУРАГ 2. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ




## ХҮСНЭГТ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, 2026 ОНЫ ЭХНИЙ V САРД

| Төсвийн орлого | | | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Татварын орлого | | | Татварын бус орлого | | |
| | Бүгд | Биелэлт % | Зөрүү сая.төг | Бүгд | Биелэлт % | Зөрүү сая.т | Бүгд | Биелэлт % | Зөрүү сая.т |
| Дүн | 69 216.7 | 77.1 | -20 581.8 | 65 859.7 | 75.6 | -21 272.7 | 3 357.0 | 1.3* | 691.2 |

## ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 ОНЫ ЭХНИЙ V САРД

| Үзүүлэлт | Батлагдсан төсөв жилээр | Төсвийн зарлага/сая.төг/ 2026 I-V | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Төсөв | Гүйцэтгэл | |
| НИЙТ ЗАРЛАГА | 223 048.1 | 82 482.9 | 67 679.2 | 82.1 |
| Урсгал зардал | 174 097.2 | 75 794.1 | 60 722.8 | 80.1 |

| Үзүүлэлт | Батлагдсан төсөв жилээр | Төсвийн зарлага/сая.төг/ 2026 I-V | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Төсөв | Гүйцэтгэл | |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 160 406.4 | 70 102.9 | 55 126.6 | 78.6 |
| Урсгал шилжүүлэг | 13 690.8 | 5 691.2 | 5 596.2 | 98.3 |
| Хөрөнгийн зардал | 48 950.9 | 6 688.8 | 6 956.4 | 104.0 |

*Мэдээллийн эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс*

Дүүргийн оны эхний V сарын төсөвт зардал 82482.9 сая төгрөг бөгөөд нийт батлагдсан төсвийн 37.0%-ийг эзэлж байна. Үүнээс 82.1 хувь буюу 67679.2 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ сарын зарцуулсан зардлын 89.7 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 10.3 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

**ЗУРАГ 3. ТӨСВИЙН ОРЛОГО, САРЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР**




Энэ оны V сард төсвийн орлогын төлөвлөгөө 21365.5 сая төгрөг, гүйцэтгэл 14401.9 сая төгрөгт хүрч гүйцэтгэл 67.4 хувь биелсэн байна. Энэ оны V сард төсвийн орлогын төлөвлөгөө 4285.3 сая төгрөгөөр өссөн бол гүйцэтгэл 2026.4 сая төгрөгөөр буурсан байна.

**ЗУРАГ 4.** **ТӨСВИЙН ЗАРЛАГА, ОНЫ ЭХНИЙ V САРААР**




2026 оны эхний V сарын төсвийн төлөвлөсөн зардал өмнөх оны мөнх үеэс 21311.5 (20.5%) сая төгрөгөөр буурсан бол гүйцэтгэл 3564.2 (5.6%) сая төгрөгөөр өссөн байна.

## Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого:
Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал:
Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Урсгал зардал:
Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Татварын бус орлого:
Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Улсын төсөв:
Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Төсвийн орлого
Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан, хуримтлалын сан болон тэнцүүэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

# НИЙГМИЙН ДААТГАЛ

**Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө оны эхний V сард 98.2%-ийн гүйцэтгэлтэй байна.**

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлогын төлөвлөгөө 2026 оны эхний V сард 107.4 тэрбум, гүйцэтгэл 105.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүний 83.4%-ийг тэтгэврийн даатгал, 8.9%-ийг тэтгэмийн даатгал, 4.7%-ийг ҮОМШӨ-ний даатгал, 3.0%-ийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

**ХҮСНЭГТ 8. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ ЭХНИЙ V САРД**

| Үзүүлэлт | 2026 I-V | |
|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| | сая төгрөг | |
| Нийт орлого | 107 398.5 | 105 496.1 |
| Тэтгэврийн даатгалын сан | 88 749.0 | 87 965.3 |
| Тэтгэмжийн даатгалын сан | 9 516.8 | 9 389.7 |
| ҮОМШӨ[1]-ний даатгалын сан | 5 839.5 | 4 957.0 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | 3 293.3 | 3 184.0 |

*[1]-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалгаалах өвчин*

**ЗУРАГ 5 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ХУВИАР**



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны V сард 199.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 53457 хүнд олгожээ. Үүний 176.1 (88.1%) тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 10.8 (5.4%) тэрбум төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 1.2 (0.6%) тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас, 11.8 (5.9%) сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас тус тус олгосон байна. Тэтгэврийн даатгалын сангийн 79.0%-ийг өндөр насны тэтгэвэр, 9.1%-ийг хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр, 3.1%-ийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 8.9%-ийг цэргийн албан хаагчийн тэтгэвэр болон бусад зардал эзэлж байна.

## ХҮСНЭГТ 9. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, ОНЫ ЭХНИЙ V САРД

| № | Үзүүлэлт | Тэтгэвэр,тэтгэмж авагчдын тоо | 2026 I-V | |
|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| | | | Өссөн дүнгээр, сая.төг | |
| | НД сангийн нийт зарлага | 54 714 | 247 498.9 | 248 150.4 |
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 46 932 | 219 552.0 | 220 393.1 |
| | 1.1. Өндөр насны тэтгэвэр | 36 886 | 173 884.8 | 174 125.2 |
| | 1.2.Хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр | 5 673 | 19 731.0 | 19 959.0 |
| | 1.3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 1 868 | 6 493.2 | 6 748.8 |
| | 1.4.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр | 2 521 | 19 417.0 | 19 545.8 |
| | 1.5.Бусад зардал | - | 25.9 | 14.2 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 5 070 | 13 298.4 | 13 214.6 |
| | 2.1.ХЧТА тэтгэмж | 2 476 | 1 268.2 | 1 317.9 |
| | 2.2.Жирэмсний болон амаржсаны | 2 004 | 9 538.4 | 10 035.5 |
| | 2.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох 2.4.тэтгэмж | 590 | 2 205.9 | 1 770.0 |
| | 2.5.Бусад зардал | - | 285.8 | 91.3 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 289 | 1 614.3 | 1 497.7 |
| | 3.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 212 | 1 257.7 | 1 156.2 |
| | 3.2.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 36 | 185.1 | 217.6 |
| | 3.3.ҮОМШӨ тэтгэмж | 41 | 86.1 | 93.4 |
| | 3.4.ҮОМШӨ сувилллын зардал | 3 | 6.3 | 0.3 |
| | 3.5.Бусад зардал | - | 79.1 | 30.3 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 2423 | 13 034.2 | 13 045.0 |
| | 4.1.Ажилгүйдлийн тэтгэмж | 2423 | 13 034.1 | 13 044.9 |
| | 4.2.Бусад зардал | - | 0.2 | 0.1 |

*Мэдээллийн эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар*

**ЗУРАГ 6.** **ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ОНЫ ЭХНИЙ V САРД**




## Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал:
Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан:
Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч:
Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр:
Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж:
Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

# НИЙГМИЙН ХАЛАМЖ

**Сонгинохайрхан дүүрэгт нийгмийн халамжийн зардал 2026 оны эхний 5 сард 843 732 иргэнд 117 242.6 сая төгрөг олгогдсон байна.**

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэршээлтэй иргэн зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрөөс иргэдээ дэмжих арга хэрэгсэл юм.

Сонгинохайрхан дүүргийн нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 5 сард 843.7 мянган хүнд 117242.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдсон байна.

**ХҮСНЭГТ 10. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, төрлөөр, 2026 оны эхний 5 сард**

| Үзүүлэлт | 2026 V | | Нийт халамжийн санд эзлэх хувь |
|---|---|---|---|
| | Хүн | Гүйцэтгэл | |
| | Тоо | Сая төгрөг | |
| **Нийт** | **843 427** | **117 199.8** | **100** |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр | 33 098 | 15 200.2 | 13.0 |
| Асаргааны тэтгэмж | 33 900 | 11 584.1 | 9.9 |
| Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж | 58 201 | 3 666.4 | 3.1 |
| Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж | 22 | 8 804.0 | 7.5 |
| Хүүхдийн мөнгө | 664 010 | 65 882.6 | 56.2 |
| Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж | 40 | 48.0 | 0.04 |
| Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж | 6 744 | 3 468.3 | 2.96 |
| Ахмад настны хөнгөлөлт, тусламж | 3 904 | 1 021.3 | 0.9 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж | 1 795 | 420.2 | 0.4 |
| Алдарт эхийн одон | 23 478 | 5 623.8 | 4.8 |
| Насны хишиг | 18 235 | 1 480.9 | 1.3 |

Олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн 65 882.6 (56.2%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 15200.2 (13.0%) сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, 11584.1 (9.9%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 8804 (7.5) сая төгрөгийг алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, 5623.8 (4.8%) сая төгрөгийг алдарт эхийн одонгийн тэтгэмж, 3666.4 (3.1%) сая төгрөгийг эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, 3468.3 (2.96%) сая төгрөгийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1480.9 (1.3%) сая төгрөгийг насны хишгийн тэтгэмж, үлдсэн 1489.5 (1.34%) сая төгрөгийг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, ахмад настны хөнгөлөлт, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж тус тус эзэлж байна.

**ХҮСНЭГТ 11.** **АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, 2026 оны эхний 5 сард**

| Үзүүлэлт | 2026 V | | Нийт ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтөнд эзлэх хувь |
|---|---|---|---|
| | Хүн | Гүйцэтгэл | |
| | Тоо | Сая төгрөг | |
| **Нийт** | **3 904** | **1 021.3** | **100** |
| Оршуулгын тэтгэмж | 22 | 49.0 | 4.8 |
| Амралт, сувилал | 1 227 | 318.9 | 31.2 |
| Рашаан сувилал | 1 014 | 357.3 | 35.0 |
| Протез | 1 410 | 185.6 | 18.2 |
| Ортопед, тусгай хэрэгсэл | 231 | 110.5 | 10.8 |

Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтийн 357.3 (35.0%) сая төгрөгийг рашаан сувилалд амрах хөнгөлөлт, 318.9 (31.2%) сая төгрөгийг амралт сувилал, 185.6 (18.2) сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу, хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт, 110.5 (10.8%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, хөнгөлөлт, 49 (4.8%) сая төгрөгийг оршуулгын тэтгэмж, тус тус эзэлж байна.

**ХҮСНЭГТ 12.** **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛ, ТУСЛАМЖ, төрлөөр, 2026 оны эхний 5 сард**

| Үзүүлэлт | 2026 V | | Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжинд эзлэх хувь |
|---|---|---|---|
| | Хүн | Гүйцэтгэл | |
| | Тоо | Сая төгрөг | |
| **Нийт** | **2 036** | **420.2** | **100** |
| Оршуулгын тэтгэмж | 64 | 196.0 | 46.6 |
| Харилцаа, холбооны зардал | 1 237 | 26.0 | 6.2 |
| Рашаан сувилал | 53 | 19.9 | 4.7 |
| Цэцэрлэг, сургуулийн унааны хөнгөлөлт | 45 | 9.0 | 2.1 |
| Ортопед, тусгай хэрэгсэл | 215 | 138.3 | 32.9 |
| Протез | 104 | 20.4 | 4.8 |
| Түлш, орон сууцны үнийн хөнгөлөлт | 77 | 10.8 | 2.6 |

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийн 196.0 (46.6%) сая төгрөгийг оршуулгын тусламж, 138.3 (32.9%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, 26.0 (6.2%) сая төгрөгийг харилцаа, холбооны зардал, 20.4 (4.8%) сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу, хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт, 19.9 (4.7%) сая төгрөгийг рашаан сувиллын хөнгөлөлт, 10.8 (2.6%) сая төгрөгийг түлш, орон сууцны үнийн хөнгөлөлт, 9 (2.1%) сая төгрөгийг цэцэрлэг сургуулийн унааны хөнгөлөлт тус тус эзэлж байна.

## Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа.

Эх үүсвэр:

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс

# ГЭМТ ХЭРЭГ

## 2026 оны эхний V сард



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

| 2025 V | 2026 V |
|---|---|
| 2 248 | 2 415 ↑ 7.4% |

Дүүргээр




Гэмт хэргийн улмаас

| Хохирсон хүн | Гэмтсэн хүн | Нас барсан хүн |
|---|---|---|
| 2 292 | 465 | 85 |

# ГЭМТ ХЭРЭГ

**Сонгинохайрхан дүүрэгт 2026 оны эхний 5 сард 2 415 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 167 (7.4%) хэргээр өссөн байна.**

Монгол улсад 2026 оны эхний 5 сард нийт 24742 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 16985 (68.6%), дүүрэгт 2415 (9.8%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 1820 (7.9%), нийслэлийн хэмжээнд 665 (4.0%), дүүргийн хэмжээнд 167 (7.4%) хэргээр тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр, 2026 оны эхний 5 сард**

| Хэлтэс | 2025 V | 2026 V | Өөрчлөлт | | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | | Тоо | Хувь | |
| **Нийт гэмт хэрэг** | 2 248 | 2 415 | 167 | 7.4 | 100.0 |
| СХДЦХ-1 | 1 122 | 914 | -208 | -18.5 | 37.8 |
| СХДЦХ-2 | 517 | 828 | 311 | 60.2 | 34.3 |
| СХДЦХ-3 | 609 | 673 | 64 | 10.5 | 27.9 |

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Цагдаагийн 2 дугээр хэлтэст 311 (60.2%), Цагдаагийн 3 дугаар хэлтэст 64 (10.5%) хэргээр тус тус өссөн бол Цагдаагийн 1 дүгээр хэлтэст 208 (18.5%) хэргээр буурсан зэрэг үзүүлэлттэй байна.

**ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, 2026 оны эхний 5 сард**

| Төрөл | 2025 V | 2026 V | Өөрчлөлт | | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | | Тоо | Хувь | |
| **Нийт гэмт хэрэг** | 2 248 | 2 415 | 167 | 7.4 | 100.0 |
| Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг | 71 | 65 | -6 | -8.4 | 2.7 |
| Хүнийг алах гэмт хэрэг | 8 | 12 | 4 | 50.0 | 0.5 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 474 | 410 | -64 | -13.5 | 17.0 |
| Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг | 8 | 4 | -4 | -50.0 | 0.2 |
| Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 27 | 43 | 16 | 59.3 | 1.8 |
| Хүчиндэх гэмт хэрэг | 27 | 14 | -13 | -48.1 | 0.6 |
| Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | 21 | 2 | -19 | -90.5 | 0.1 |
| Хүүхдийн эсрэг гэмт хэрэг | 2 | 2 | - | - | 0.1 |
| Хулгайлах гэмт хэрэг | 532 | 479 | -53 | -10.0 | 19.8 |
| Дээрэмдэх гэмт хэрэг | 83 | 69 | -14 | -16.9 | 2.9 |
| Залилах гэмт хэрэг | 623 | 894 | 271 | 43.5 | 37.0 |
| Хөрөнгө завших гэмт хэрэг | 37 | 27 | -10 | -27.0 | 1.1 |
| Алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг | 65 | 68 | 3 | 4.6 | 2.8 |

| Төрөл | 2025 V | 2026 V | Өөрчлөлт | | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | | Тоо | Хувь | |
| Авто тээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах гэмт хэрэг | 15 | 10 | -5 | -33.3 | 0.4 |
| Эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэрэг | 48 | 51 | 3 | 6.25 | 2.1 |
| Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг | 10 | 39 | 29 | 3.9** | 1.6 |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 17 | 33 | 16 | 94.1 | 1.4 |
| Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | 11 | 7 | -4 | -36.4 | 0.3 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг | 10 | 8 | -2 | -20.0 | 0.3 |
| Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 22 | 47 | 25 | 2.1** | 1.9 |
| Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 137 | 131 | -6 | -4.4 | 5.4 |

